

## “Байгаль Орчны Шинэчлэл -2” төсөл

### Удирдамж - 2011

Нидерландын Вант Улсын Засгийн Газрын Итгэлийн Сангийн санхүүжилтээр Монгол орны байгаль орчны засаглалыг бэхжүүлэх, хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн менежментийг сайжруулах зорилгоор Дэлхийн Банк болон Монгол улсын Байгаль Орчны Яам хамтран “Байгаль Орчны Шинэчлэл – 2” төслийг хэрэгжүүлж эхлээд байна. 2007- 2011 онд хэрэгжиж буй энэхүү төслийн хүрээнд 2011 оны жижиг төслийн тэтгэлэгт уралдааныг зарлаж байна. Энэ жилийн хувьд төслийн гол сэдэв нь орон нутгийн байгаль орчны менежментийг сайжруулахад ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэж байгаагаараа онцлогтой.

#### Тэтгэлэгт хэн хамрагдаж болох:

1. Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулах боломжтой төрийн бус байгууллага, эрдэмтэн болон судлаач, мэргэжилтнүүдийн баг, нутгийн иргэдийн нөхөрлөл, хамтлаг, малчдын бүлэг болон хувь хүмүүсийг.

2. 2005 оноос хойш “Байгаль Орчны Шинэчлэл” төслийн тэтгэлэгт уралдаанд шалгарч амжилттай төсөл хэрэгжүүлсэн байгууллага, хувь хүмүүс

Төсөл санаачлагч нь хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагааны чиглэлээр зохих мэдлэг туршлагатай байх шаардлагатай.

#### Гол сэдвүүд

Ой, ус, биологийн төрөл зүйлийг хамгаалах замаар цөлжилтийн явцыг сааруулах, орон нутагт тохирсон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох оновчтой, шинэлэг, бусад орон нутагт түгээн дэлгэрүүлэх боломжтой арга ажиллагааг бий болгох, үүний тулд:

- Ойг түлшинд хэрэглэх хэрэгцээг багасгаж, айл өрхийн түвшинд модыг орлуулах үр ашигтай нь батлагдсан арга замыг түгээн дэлгэрүүлэх
- Тал хээр говийн бүсэд булаг шанд, усны эхийг хамгаалах, ус хэмнэлттэй ашиглах талаар шинэлэг, оновчтой, бусад газарт түгээн дэлгэрүүлэх боломжтой үйл ажиллагаа
- Улсын төсвөөс санхүүжиж байгаа орон нутгийн байгаль хамгаалах сан, хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтэнд олон нийтийн хяналтыг бий болгох
- Ургамлын нөмрөг, бэлчээр, хөрсийг хамгаалах, гамтай ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр улсын хэмжээнд тэргүүн туршлага болохуйц үйл ажиллагаа
- Хоггүй цэвэр орчинд амьдрах, хог хаяхгүй байх талаар хүүхэд залуучуудын ухамсар, төлөвшилд нөлөөлөхүйц шинэлэг, оновчтой, бусад газарт түгээн дэлгэрүүлэх боломжтой үйл ажиллагаа
- Орон нутгийн түвшинд уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд дасан зохицож амьдрах ухаан, арга барилд ард иргэдийг сургах, тэдэнд шаардлагатай мэдлэг олгох, мэдээллээр хангахад чиглэсэн арга хэмжээ,

Байгаль орчны гэмт хэрэг, зөрчлийг багасгахад орон нутгийн захиргаа, байгаль орчны байгууллага, байцаагч, байгаль хамгаалагчдад, иргэдийн нөхөрлөлийн зүгээс дэмжлэг үзүүлэх, хамтын оролцоотой хяналтын тогтолцоог бүрдүүлэх

- Ойтой бүс нутгаар ой модны хулгайг таслан зогсооход төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоотой олон нийтийн хяналтын тогтолцоо (улс, аймаг, сум, аймаг

хоорондын, сум хоорондын гэх мэт)-г бий болгож цаашид тогтвортой ажиллах оновчтой механизм бүрдүүлэх

- Ховор, ховордсон болон хорио тавьсан ангийн хулгайг зогсоох олон нийтийн оновчтой хяналт
- Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, түймэр гарах нөхцлийг арилгах, түймэр тавигчдыг илрүүлэх ажилд нутгийн иргэдийн оролцоо, орон нутгийн хяналтын оновчтой тогтолцоо
- Орон нутагт ашигт малтмал хайх, ашиглах явцад холбогдох хууль тогтоолын хэрэгжилтийг хангуулахад иргэдийн оролцоо, хяналт
- Байгаль орчны хэрэг, зөрчил, байгалийн гамшгийн үед цаг алдалгүй арга хэмжээ авах боломж олгоход чиглэсэн мэдээлэл дамжуулах тогтолцоог бий болгох оновчтой шийдэл, үйл ажиллагаа

Дээрх сэдвүүдээс гадна 2005 оноос хойш “Байгаль Орчны Шинэчлэл” төслийн хүрээнд амжилттай хэрэгжсэн жижиг төслүүдийн үйл ажиллагааны тогтвортой үргэлжлэх нөхцөлийг дэмжих зорилгоор өмнөх жилүүдэд төсөл хэрэгжүүлсэн багуудаас төслийн санал хүлээж авна.

**Тэтгэлгийн хэмжээ:** 25,000 ам.доллар хүртэл

**Төсөл хэрэгжүүлэх хугацаа:** 2011 оны гуравдугаар сараас 12 сар хүртэлх хугацаанд хэрэгжиж үр дүн нь харагдахуйц төслүүд

**Төсөл хүлээн авах эцсийн хугацаа:** 2011.01.07-ны Баасан гариг, 18.00 цаг. Материалыг Нээлтэй Нийгэм Форумын байранд хүлээн авах ба э-шуудангийн [project@forum.mn](mailto:project@forum.mn) хаягаар мөн ирүүлж болно. Э-шуудангаар төсөл хүлээн авах журамыг анхааралтай уншиж танилцсаны дагуу төслөө илгээнэ үү (Журмыг удирдамжийн ард хавсаргав)

Э-шуудангаар төсөл хүлээн авах журам, өргөдлийн маягт болон удирдамжийг Нээлтэй Нийгэм Форумын байрнаас, эсвэл [www.forum.mn](http://www.forum.mn) болон [www.mne.mn](http://www.mne.mn) вэб сайтаас татан авна уу.

Дэлгэрэнгүй мэдээллийг авахыг хүсвэл ННФ-аас зохион байгуулах Мэдээлэл өгөх уулзалтанд оролцохыг урьж байна. Уулзалт нь 2010 оны 12 сарын 13 болон 22-ны 16:00 цагт ННФ-ын хурлын зааланд болно. Хөдөө орон нутгаас оролцохыг хүссэн хүмүүс дэлгэрэнгүй мэдээлэл болон өргөдлийн маягтыг аймгийн төв номын сан болон Байгаль орчны албадуудаас авах боломжтой.

***Ирүүлэх материалууд:***

Дараах бичиг баримтуудыг төслийн саналын хамт хавсарган ирүүлнэ. Үүнд.

- Төслийг монгол хэлээр бичнэ
- Байгууллагын танилцуулга  
(Багаар оролцож байгаа бол гишүүдийн талаарх мэдээлэл, CV )
- Байгууллагын бүртгүүлсэн гэрчилгээний хуулбар
- Хувь хүмүүсийн хувьд иргэний үнэмлэхийн хуулбар

***Сонгон шалгаруулалт явуулах журам:***

Төслийн саналуудыг төрийн болон төрийн бус, эрдэм шинжилгээний байгууллагуудын төлөөлөгчдийн бүрэлдэхүүн бүхий Сонгон шалгаруулах хороо шалгаруулна. Сонгон шалгаруулалт 2 үе шатаар явагдах ба эхний шатанд ирүүлсэн төслүүдийн иж бүрдэл (Шаардлагад заасан материалуудын бүрдэл) болон төсөл нь зарласан сэдвүүдэд нийцэж байгаа эсэхийг шалгана. Төслийн материал дутуу бол эхний шатны шалгаруултаас хасагдахыг анхаарна уу.

Эхний шатнаас шалгарсан төслүүдийг сонгон шалгаруулах хороогоор хэлэлцүүлж дараах шалгууруудыг голчлон төслүүдийн шалгаруулалтыг хийнэ. Үүнд: Төслийн зорилго оновчтой, хүрэх боломжтой эсэх; Үр дүн бодитой хэмжигдэхүйц, тодорхой бүтээгдэхүүн гаргахад чиглэгдсэн эсэх; Хэрэгжүүлэх арга зам нь тодорхой, оновчтой байхаас гадна бусад орон нутагт тохируулан хуулбарлах, дэлгэрүүлэх боломжтой эсэх, үйл ажиллагаа бодитой, нарийн төлөвлөгдсөн эсэх, төсөв бодитой тооцогдсон байх, төслийн үйл ажиллагаа тогтвортой үргэлжлэх боломж, бусад хөтөлбөр, төсөл, санаачлагатай уялдсан байдал, болон төсөл хэрэгжүүлэгчийн ижил төстөй ажлын туршлагатай эсэхийг харгалзан төслийг үнэлнэ.

Шалгаруулалтын эцсийн дүнг материал хүлээн авах сүүлчийн өдрөөс хойш 45 хоногийн дотор олон нийгэд ил тод зарлаж шалгарсан байгууллагуудын талаарх мэдээллийг Нээлттэй Нийгэм Форумын вэбсайт болон өдөр тутмын сонинуудаар мэдээлнэ.

Шалгараагүй төслүүдийг Сонгон шалгаруулах хорооны хурлын шийдвэр гарснаас хойш 6 сарын дотор буцаан авах боломжтой.